



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 9/90

Улаанбаатар хот

Равжирын Сарантуяаг цэргийн алба  
хаасны тэтгэвэр тогтоолгохоор албан тушаалаас  
чөлөөлөх тухай

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.1.5, 280 дугаар зүйлийн 280.2, 286 дугаар зүйлийн 286.7, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах нягтлан бодогч, дэд хурандаа Равжирын Сарантуяа нь цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон албан тушаалаас нь чөлөөлсүгэй.
2. Р.Сарантуяаг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл цэргийн албанд биеэр 21 жил 01 сар 09 хоног, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласан хугацааны нэмэгдэл 03 жилийг нэмж тооцон, цэргийн албанд нийт 24 жил 01 сар 09 хоног ажилласнаар тооцсугай.
3. Р.Сарантуяад 36 (гучин зургаа) сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар (хурандаа С.Батбямба)-т зөвшөөрсүгэй.
4. Р.Сарантуяагийн ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоо хийхийг Шийдвэр гүйцэтгэх алба (дэд хурандаа Б.Дашдаваа)-нд даалгасугай.

ДАРГА, ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН:  
Захиргааны удирдлагын  
газрын дарга, хурандаа  
2022.02.11



Д.ЗАГДЖАВ

Ч.Нэргүй